

МОНГОЛ, ХЯТАДЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ЭРЧИМЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, БОЛОМЖ

Б.Галаарид*

* МСЭ-ийн ерөнхийлөгч, МУБИС-ийн докторант

Түлхүүр үг: хэвлэл мэдээллийн байгууллагууд, хамтын ажиллагаа, найрсаг түншлэл, Синьхуа агентлаг, МОНЦАМЭ агентлаг, офсет хэвлэлийн үйлдвэр

Монголын хэвлэл мэдээллийн байгууллагуудын гадаад хамтын ажиллагааны хөгжлийн асуудал нь тусгайлан судалбал зохих сэдэв мөн. Ялангуяа гадаад харилцаа өргөжсөн, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн үйл ажиллагаан дахь үзэл суртлын хаалт хориг арилсан, энэ салбар үндсэндээ тэр чигээрээ хувийн өмчид тулгуурлах болсон сүүлийн хорь гаруй жилд энэ чиглэлд гарсан өөрчлөлтийг судлан дүгнэх, үгүйдээ гэхэд тоймлон түүхчлэх шаардлагатай байна.

Энэ өгүүлэл асуудлыг ийм өргөн цар хүрээтэйгээр хөндөх зорилго тавиагүй бөгөөд үзэл суртлын зөрүүтэй байр суурийн улмаас хамтын ажиллагаа нь хэсэг хугацаагаар тасалдсан Монгол-Хятадын хэвлэл мэдээллийн байгууллагуудын харилцааны асуудлыг цухас авч үзсэн болно. Хоёр орны хамтын ажиллагаа бүх салбарт нэн эрчимтэй хөгжиж байгаа өнөө үед хэвлэл мэдээллийн харилцааны асуудлыг судлах нь өөрөө чухал ач холбогдолтой юм.

Хоёр орон, ард түмний харилцан түншлэл, хамтын ажиллагааны түүх өвөрмөц бөгөөд баялаг билээ. Ялангуяа сүүлийн хориод жилд энэ түүх олон чухал үйл явдал, шинэ шинэ хуудсаар баяжаар байна. Үндсэн сэдэвт орохоос өмнө хоёр орны харилцааны нэн шинэ түүхийн талаар товч тоймлох нь зүйтэй гэж үзлээ.

Тодорхой нөхцөл шалтгааны улмаас хэсэг хугацаанд идэвх султай байсан хоёр орны харилцаа 1980-аад оны сүүлийн хагасаас бага багаар сэргэж эхэлжээ. 1951 оноос эхтэй Монгол-Хятадын худалдааны харилцаа 1989 онд Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Хятад, Монголын комисс байгуулагдсанаар шинэ сэргэлтийн үедээ оров. Засгийн газар хоорондын худалдаанаас гадна хилийн худалдаа хөгжих үндэс суурь мөн тэр үеэс тавигджээ. Энэ бүхний үр дүнд БНХАУ өнөөдөр манай орны худалдааны хамгийн том түнш болоод байна.

1952 оноос эхтэй боловсролын солилцооны түүхэнд ч шинэ шинэ хуудас нэмэгдсээр байна. 1996 онд Монгол Улсын Шинжлэх ухаан, гэгээрлийн яамны сайд БНХАУ-д айлчлал хийсэн нь хоёр орны соёл, боловсрол,

шинжлэх ухааны хамтын ажиллагааны хөгжилд түлхэц өгсөн чухал үйл явдлын нэг байлаа.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга П.Очирбат 1990 онд БНХАУ-д, БНХАУ-ын дарга Ян Шанкунь 1991 онд БНМАУ-д албан ёсны найрсаг айлчлал хийж, Монгол Улсын Ерөнхий сайд Д.Бямбасүрэн 1992 онд БНХАУ-д, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэн 1994 онд Монгол Улсад тус тус айлчилж, айлчлал болгон тодорхой хэмжээний зөвшилцөл, харилцан ойлголцлыг авчирчээ.

Энэ бүхний үндсэн дээр хоёр орны харилцаа эрс идэвхжиж, 1994 онд талууд "Монгол, Хятад хоёр орны найрсаг хамтын ажиллагааны гэрээ"-нд гарын үсэг зурснаар энэхүү найрсаг харилцаа тогтвортой хөгжих улс төр, эрх зүйн үндэс суурь нь бүрэн тавигдсан гэж хэлж болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди 1998 оны 12-р сард Хятадад, БНХАУ-ын дарга Зян Зэминь 1999 оны 7-р сард Монголд төрийн айлчлал хийж хоёр талын шинэ зууны хамтын ажиллагааны зүг чигийг тодорхойлсон төдийгүй, дараа дараагийн төрийн тэргүүнүүдийн өндөр дээд хэмжээний айлчлалуудын эхлэлийг тавьсан юм.

Талуудын хүчин чармайлт, хичээл зүтгэлийн үр дүнд өнөөдөр Монгол, Хятадын харилцаа, олон талт хамтын ажиллагаа агуулга хэлбэрийн хувьд улам бүр баяжиж, дээд түвшинд хүрсний баталгаа нь 2014 оны зун БНХАУ-ын дарга Си Зиньпиний Монголд хийсэн айлчлалын үеэр хоёр орны төрийн тэргүүн Монгол, Хятадын харилцааг иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаанд шилжүүлэх тохиролцоонд хүрсэн явдал юм. Ноён Си Зиньпин УИХ-ын хүндэтгэлийн хуралдаан дээр үг хэлэхдээ "Айл хүний амь"

нэг, саахалт хүний санаа нэг гэж Монголчууд ярьдаг. Харин бид Сайн хөршийг алтаар солихгүй гэдэг"¹ хэмээсэн нь хоёр орны харилцаанд Хятадын зүгээс баримтлах бодлогыг нэн тодорхой илэрхийлсэн хэрэг юм.

Хоёр орны хэвлэл мэдээллийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагааны түүхэн замнал нь тусгайлан судалбаас зохих сэдвийн нэг бөгөөд өөрийн гэсэн арвин баялаг түүхтэй. Хоёр орны мэдээллийн хамгийн том агентлагууд болох Синьхуа, МОНЦАМЭ гэхэд л 1958 оноос хойш тасралтгүй харилцаатай ажиллаж байна. Хоёр орон олон жилийн турш сурвалжлагч харилцан суулгаж, хэвлэл мэдээллийнхэнд харилцан сурвалжлах боломж олгосоор иржээ.

Улс төрийн бодлого дагаад 1950-1960-аад оны үед хоёр орны хэвлэл мэдээллийнхэн ихээхэн ойр дотно ажиллаж, төрийн бодлогын хэмжээнд энэ харилцааг дэмжиж байсан нь БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Энълай 1961 оны 7-р сарын 9-нд "Хятад, Монголын найрамдлын өдрүүд"-эд оролцохоор ирсэн Монголын урлаг соёл, хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөгчдийг тусгайлан хүлээн авч уулзсанаас тодорхой байна².

Тэр үед хоёр орны хэвлэл мэдээллийн салбарынхан хэрхэн нөхөрлөж, бие биедээ тусалдаг байсан тухай, мөн баримт, мэдээлэл олохын төлөө сэтгүүлч хэрхэн бүх боломжоо дайчлах ёстойн сонгодог жишээ гэмээр нэгэн түүх байна.

1961 онд Монгол ардын армийн 40 жилийн ойд БНХАУ-ын БХЯ-ны нэгдүгээр орлогч сайд, армийн генерал Сюй Гуан-да оролцох болжээ. Тэр үед сониныг хэд хоногийн өмнө хэвлэлтэд бэлддэг байсан бөгөөд даваа гарагт

хэвлэгдэх сонинд Хятадын генералын зураг намтрыг олж нийтлэх үүрэг бямба гарагт цэргийн төв хэвлэл "Улаан од" сонины эрхлэгч Ж.Ядмаад оногджээ. Тэрбээр Хятадын Элчин сайдын яаманд ажилладаг Синьхуа хорооны төлөөлөгч, Гадаад явдлын яам, Батлан хамгаалах яам гээд туслаж болох бүх газартай холбогдсон ч тэр генералын тухай мэдээлэл олдоогүй тул эцсийн боломжоо ашиглаж

Хятадын цэргийн сонины эрхлэгч рүү утасдсан байна. Хятадын цэргийн сонины эрхлэгч, генерал Ху-ран тусгай онгоцоор сайдын зураг намтрыг илгээж, Ж. Ядмаа эрхлэгч тэрхүү онгоц Улаанбаатарт саадгүй буух зөвшөөрлийг яаралтай зохицуулснаар цэргийн төв сонины баярын дугаарт хүндэт зочны зураг, намтрыг хэвлэж амжсан байна³.

Энэ мэтээр харилцан нөхөрлөж, хамтран ажиллаж байсан уламжлал улс төрийн тодорхой нөхцөл шалтгааны улмаас хэсэг хугацаанд тасалдаад 1990-ээд оноос эргэн сэргэж эхэлжээ. "Үнэн", "Улаан од" зэрэг сонин 1991-1992 онд өөр өөрийн чиглэлийн сонинуудтай харилцаагаа сэргээж, нийслэлийн төр, захиргааны "Улаанбаатар" сонин гэхэд л хамтын ажиллагааны цоо шинэ хэлбэрийг бий болгож, "Хөх хотын өдрийн сонин"-той харилцаа тогтоон, улмаар шинэ технологи нутагшуулж орчин үеийн офсет хэвлэлийн үйлдвэртэй болсон байна. Хятадын олон улсын радио 1993 оноос Монголын үндэсний радиотой хамтран

ажиллаж, мэргэжилтэн солилцдог болов. Хоёр орны ХМХ хоорондын хамтын ажиллагааны энэ мэт жишээ олныг дурдаж болох бөгөөд ардын дипломатын энэхүү харилцаа тэлэн хөгжсөөр төр засгийн бодлогын суурь хөрс нь болж эхэлсэн байна.

Монголын Сэтгүүлчдийн Эвлэлийн үе үеийн удирдлага Монгол, Хятадын хэвлэл мэдээллийн салбарынхны хамтын ажиллагааг хөгжүүлэхийн төлөө

«
2011 оноос МСЭ, ӨМӨЗО-ны Ардын Засгийн газрын ХМА-ны хооронд хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажигладаг болсон, Монгол, Хятадын хэвлэл мэдээллийн жил тутмын форум тогтмолжиж, 2014 онд 5 дахь удаагаа зохион байгуулагдсан, сэтгүүлчдийн баг харилцан солилцож хэвшсэн явдал юм

»

хичээл зүтгэл гаргаж, Бүх Хятадын сэтгүүлчдийн холбоо, ӨМӨЗО-ны Ардын Засгийн газрын хэвлэл мэдээллийн алба зэрэг түнштэйгээ хамтран ажилласнаар бодитой үр дүнд хүрчээ. Үүний нэг тод жишээ нь 2011 оноос МСЭ, ӨМӨЗО-ны Ардын Засгийн газрын хэвлэл мэдээллийн албаны хооронд хам-

тын ажиллагааны гэрээ байгуулан ажилладаг болсон, Монгол, Хятадын хэвлэл мэдээллийн жил тутмын форумын үйл ажиллагаа тогтмолжиж 2014 онд 5 дахь удаагаа зохион байгуулагдсан, тодорхой давтамжтайгаар сэтгүүлчдийн баг харилцан солилцож хэвшсэн явдал юм.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Кецянь нар 2013 оны 10-р сард Бээжин хотноо гарын үсэг зурсан "Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр"-ийн дөрөвдүгээр буюу "Хэвлэл мэдээллийн байгууллагуудын солилцоо" гэсэн хэсэгт "Талууд

Монгол, Хятадын хэвлэл мэдээллийн форумыг жил бүр ээлжлэн зохион байгуулна⁴ гэж зааснаар сэтгүүлчдийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгуулагын түвшинд хийгдэж байсан ажил хоёр орны Засгийн газрын бодлогод тусгалаа олсон байна.

Уг хөтөлбөрт хоёр улсын ГХЯ-дын хэвлэл мэдээллийн зөвлөлдөх уулзалтын механизм бий болгох асуудлыг тусгасны дагуу Монгол Улс, БНХАУ-ын Гадаад хэргийн яамдын хэвлэл мэдээллийн асуудал эрхэлсэн газрын захирлуудын анхдугаар зөвлөлдөх уулзалт 2014 оны 1-р сард Бээжин хотноо болоход МСЭ-ийг төлөөлж Ерөнхий нарийн бичгийн дарга Х.Батхишиг тэргүүтэй төлөөлөгчид оролцсон байна. Мөн МСЭ-ийн Ерөнхийлөгч Б.Галаарид тэргүүтэй төлөөлөгчид 2014 оны эхээр Бүх Хятадын сэтгүүлчдийн холбооны урилгаар БНХАУ-д зочилж, тус холбоотой хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан нь хоёр улсын хэвлэл мэдээллийн салбарынхны хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлэх талаар хийсэн бас нэгэн чухал алхам болсон байна.

Хэвлэл мэдээллийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах талаар төрөөс баримтлах бодлого дээр хоёр орны төр засгийн байр суурь нэгдмэл байгааг нотолсон дараагийн нэгэн чухал баримт бичиг бол Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, БНХАУ-ын дарга Си Зиньпин нар Улаанбаатарт гарын үсэг зурсан "Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэл, харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал" юм. Энэхүү тунхаглалд "Талууд цаашид хоёр улсын хэвлэл, мэдээллийн харилцан солилцоог улам идэвхжүүлж, зөвлөлдөх уулзалт, форум зэрэг хамтын ажиллагааны механизмыг

ашиглан кино, телевизийн нэвтрүүлэг хийх, дамжуулан нэвтрүүлэх, харилцан солилцоог хөгжүүлэхэд таатай нөхцөлийг бүрдүүлнэ⁵ гэж заасан нь хоёр орны хэвлэл мэдээллийн салбарын хамтын ажиллагааг төр засгийн хамгийн өндөр дээд түвшинд дэмжсэн чухал шийдвэр болжээ.

Төр засгийн түвшинд энэ бүх бодлого шийдвэр нь Монгол, Хятадын хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэх арга зам, боломжийг нэмж өгч байгаа бөгөөд үүнийг хэрхэн үр дүнтэй ашигласнаар хамтын ажиллагааны үнэ цэн тодорхойлогдох юм. Өөрөөр хэлбэл, хоёр орны хэвлэл мэдээллийн салбарын хамтын ажиллагааг урьд өмнө байгаагүй өндөр түвшинд хөгжүүлэх бүх талын боломж нээлттэй байна.

Хоёр орны хэвлэл мэдээллийн салбарын хамтын ажиллагааг цаашид илүү ихээр хөгжүүлэх, илүү сайн үр дүнд хүрэхийн тулд:

- Сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллаж, харилцан туслалцах арга механизмыг боловсронгуй болгох;

- Хүмүүнлэг, соёлын аливаа хамтын ажиллагаанд хоёр орны хэвлэл мэдээллийн салбарынхныг өргөнөөр оролцуулдаг байх;

- Адил төстэй хэвлэл мэдээллийн байгууллагуудын шууд түншлэл, ажил хэрэгч харилцаа, хамтын ажиллагааг бүх талаар дэмжих;

- Хил орчмын аймаг, мужууд, орон нутгийн хэвлэл мэдээллийн салбарынхан харилцан туршлага солилцох, хамтран ажиллах үр дүнтэй тогтолцоог бий болгох;

- Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн чиглэлээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулийн эрдэм-

тэн багш нар харилцан туршлага солилцдог, эрдэм шинжилгээний бүтээлүүдээ харилцан нийтлүүлдэг механизм бий болгох;

- Сэтгүүлчид тодорхой сэдвээр харилцан сурвалжлах, хамтран сурвалжлах, харилцан нийтлэх нэвтрүүлэх нөхцлийг бүрдүүлэх;

- Харилцан мэргэжил дээшлүүлэх, технологи солилцох нөхцлийг бүрдүүлэх;

- Хэвлэл мэдээллийнхэн бүтээлээ харилцан солилцох үйл ажиллагааг бодлогоор дэмжих шаардлагатай байна.

Ишлэл

¹ УИХ-ын чуулганы хүндэтгэлийн хуралдаан дээр 2014.08.23-нд БНХАУ-ын дарга Си Зинпиний хэлсэн үгээс <http://www.bataar.mn/10026127>

² 2009. "БНХАУ, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жил". Бээжин, х. 206.

³ http://www.soyombo.mod.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=1358:2013-10-21-04-59-22&catid=41:2011-03-31-19-19-40&Itemid=60

⁴ "Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг

хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр" <http://www.zasag.mn/news/view/3468>

⁵ "Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэл, харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал" <http://www.president.mn/content/4116>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. 2009. "БНХАУ, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жил". Бээжин.

2. Зилькафиль М., Чойсамба Ч. 2006. Сэтгүүл зүйн түүх. УБ.

3. Бүрээчин Дархан. 2002. Дундад улсын сонин мэдээний түүхэн тойм. Хөххот.

4. Ли Д. 2000. Пресса Китая в условиях экономической реформы (90-е годы XX века). СПб.

5. Ян Чжи, Тянь Юехун. 2011. Современная журналистика Китая: вечерняя пресса, региональное радио. Минск.

6. Сергей Михайлов, Ли Динсинь, Чжан Хэфэн, У Ли, Чуу Джуэй-Хуэй. 2006. Журналистика Китая. М.

7. Сергеев Г. И. 1989. От дигао до "Женьминь жибао". Путь в 1200 лет. История средств массовой информации Китая. М.